

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 12 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Анужин, Б.Баттөмөр, Б.Бейсен, Б.Жаргалмаа, С.Одонтуяа нарын гишүүдээс 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид өндөр насны тэтгэврийг нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн 5 жилийн дундаж цалингаар тогтоодог байсныг 2018 онд нэмэгдүүлэн дараалсан 7 жил болгосон нь иргэдийн гар дээр ирэх тэтгэврийн дүнг багасгасан. Иймд өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг тооцох хугацааг 5 жил болгон бууруулахаар хуулийн төслийг боловсруулжээ.

Хуульд өөрчлөлт оруулахтай холбогдуулан улсын төсөв болон эдийн засагт хүндрэл учрахгүй гэж хуулийн төслийг санаачлагчид үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам уг хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын багц хуулийн төсөлтэй уялдаж байгаа эсэх, тэтгэвэр тогтоолгож байгаа иргэдийн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг арилгах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен тэтгэврийг инфляцийн түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа тэтгэврийн зөрүүг арилгах талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа олон хүүхэд гаргасан эмэгтэйчүүдийн тэтгэвэр бага тогтоогддог тул цаашид анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат дараалсан 7 жилийг 5 жил болгосноор сайн дурын даатгуулагч болон хувийн салбарт ажиллаж байгаа иргэд сүүлийн 5 жилийн шимтгэлийг нэмэгдүүлж төлснөөр тэтгэврээ өндөр тогтоолгох боломжтой бол төрийн албан хаагчдад энэ боломж хязгаарлагдмал байгаа нь шударга бус нөхцөл байдлыг үүсгэж байгаа талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ** **С.ЧИНЗОРИГ**

